

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СҮМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛ  
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТӨАОНӨГ/202012066

Зуунмод сум  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020-01-29

**[Төв аймгийн Эрүүл мэндийн газар]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн лабораторын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэх цахим тендерт урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн ААНэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (**PDF**) файлаар илгээнэ.

Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ **100 mb**, нэг файлын хэмжээ **15 mb**, байна.

Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж **50,000 /тавин мянган/ төгрөгийг ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр банкны Е-Меркантийн системийг ашиглан төлнө.** Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 цаг 00 минут-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлсэн байна.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **Зуунмод сумын 6-р /БаруунЗуунмод/ баг Төр, захиргааны 2 дугаар байр 2 давхар 201 тоот өрөө, Худалдан авах ажиллагааны алба 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 цаг 40 минут-д** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **“Тооцохгүй”.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Төв аймаг, Зуунмод сум 6-р баг,  
Орон нутгийн өмчийн газар,  
Аймгийн Төр, Захиргааны 2 дугаар байр, 201 тоот өрөө,  
Утас: 7027-3579,  
Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим Систем  
[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br><b>2.3.</b> Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1.</b> Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-НЫХОЛБОГОДОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2018, 2019] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Ижил төстэй ажлын өртөг нь санал болгож үнийн 100 хувиас багагүй байна.</p> <p>Бусад нэмэлт шаардлага: Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл,</li> <li>3. Үнийн саналыг тендерийн жишиг маягтаар ,</li> <li>4. Дөрөвдүгээр бүлэгт заасан маягтыг ирүүлнэ.</li> <li>5. Тендерт оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл</li> <li>6. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн тодорхойлолт /төсөвт өртгөөс багагүй байна./</li> <li>7. Шүүхийн тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна./</li> <li>8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна./</li> <li>9. Татварын газрын тодорхойлолт -tatvarын цахим тайлангийн системээс авсан бар код бүхий тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх. /</li> <li>10. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна./</li> <li>11. Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банкуудаас тодорхойлолт , лавлагаа авахад татгалзах зүйлгүй талаарх мэдэгдэл ирүүлэх.</li> <li>12. Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч буй эсэх тухай мэдэгдэл</li> <li>13. Нийлүүлэх бараанд чанарын баталгааг 1 жилийн хугацаагаар гаргаж, албан мэдэгдэл ирүүлэх</li> <li>14. Чанарын баталгааны хугацаанд нийлүүлэх барааны засвар үйлчилгээг бүрэн хариуцах тухай албан бичиг ирүүлэх</li> <li>15. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтыг ирүүлэх</li> <li>16. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь</li> <li>17. Компанийн танилцуулга</li> <li>18. Санал болгож буй бараа тендерийн барим бичигт нийцэж буйг харьцуулсан харьцуулалт</li> <li>19. Өмнө хэрэгжүүлж байсан ижил төстэй ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх</li> <li>20. Нийлүүлэх барааны үйлдвэрлэгчийн каталог зааврыг монгол хэл дээр орчуулж, ирүүлэх</li> <li>21. Эрх бүхий тендерт оролцогчийн удирдах ажилтан болон ажилчдын дэлгэрэнгүй мэдээлэл /иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн үнэмлэх, диплом зэргийг хуулбарлан ирүүлнэ./</li> <li>22. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзахгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг бүрэн ирүүлнэ</li> </ol>

	<p>ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>[шаардлагатай]</b></p> <p>23. Эм, эмнэлгийн хэрэгсэл, төхөөрөмж, оношлуур, биологийн идэвхит бүтээгдэхүүн нийлүүлэх, импортлох, худалдах Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</p>
--	---

<b>ТОӨЗ 2.1</b>	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )–д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ. Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</b> Цаг: <b>[15 цаг 00 минут]</b>
<b>ТОӨЗ 2.1</b>	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>[Төв аймаг Зуунмод сум Баруун Зуунмод 6-р баg]</b> Давхар болон өрөөний дугаар: <b>[Төр захиргааны 2-р байр 2 давхар 201 тоот]</b> Огноо: <b>/2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</b> Цаг: <b>15 цаг 40 минут</b>
<b>ТОӨЗ 2.3</b>	Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: 1. Сүүлийн <b>[2018, 2019]</b> туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; Ижил төстэй ажлын өртөг нь санал болгож үнийн 100 хувиас багагүй байна. 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл, 4. Үнийн саналыг тендерийн жишиг маягтаар , 5. Дөрөвдүгээр бүлэгт заасан маягтыг ирүүлнэ. 6. Тендерт оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл 7. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн тодорхойлолт 8. Шүүхийн тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна./ 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна./ 10. Татварын газрын тодорхойлолт –татварын цахим тайлангийн системээс авсан бар код бүхий тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх. / 11. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /тодорхойлолтыг 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзэх бөгөөд тендер хүлээн авах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна./ 12. Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банкуудаас тодорхойлолт , лавлагaa авахад татгалзах зүйлгүй талаарх мэдэгдэл ирүүлэх. 13. Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч буй эсэх тухай мэдэгдэл 14. Нийлүүлэх бараанд чанарын баталгааг 1 жилийн хугацаагаар гаргаж, албан мэдэгдэл ирүүлэх 15. Чанарын баталгааны хугацаанд нийлүүлэх барааны засвар үйлчилгээг бүрэн хариуцах тухай албан бичиг ирүүлэх 16. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтыг ирүүлэх 17. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь 18. Компанийн танилцуулга 19. Санал болгож буй бараа тендерийн барим бичигт нийцэж буйг харьцуулсан харьцуулалт 20. Өмнө хэрэгжүүлж байсан ижил төстэй ажлын гэрээний

	<p>хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх</p> <p>21. Нийлүүлэх барааны үйлдвэрлэгчийн каталог зааврыг монгол хэл дээр орчуулж, ирүүлэх</p> <p>22. Эрх бүхий тендерт оролцогчийн удирдах ажилтан болон ажилчдын дэлгэрэнгүй мэдээлэл /иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн үнэмлэх, диплом зэргийг хуулбарлан ирүүлнэ./</p> <p>23. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзахгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг бүрэн ирүүлнэ</p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b></p> <p><b>[дэс дугаар; багцын жагсаалт болон багцад хамаарах бараанууд]</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:**  
[Техникийн тодорхойлолтыг дэлгэрэнгүйгээр, захиалагчаас ирүүлснээр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд нийтэлсэн болно.]
- 2. Стандарт:**
- 3. Баглаа, боодол:** [Барааг эцсийн цэг хүртэл эвдэрч, гэмтэхээргүйгээр баглаа, боодолтой байлгана.]
- 4. Бараа хүргэх газар:** [Төв аймаг, Зуунмод сум 1-р баг, Эрүүл мэндийн газар, өөрийн байранд]
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Захиалагчтай байгуулсан гэрээнд заасан нөхцлөөр байна.

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Шээсний шинжилгээний хагас автомат анализатор	<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтэлсэн Техникийн тодорхойлолтод зааснаар	1	Ширхэг	Төв аймаг, Зуунмод сум 1-р баг, Эрүүл мэндийн газар, өөрийн байранд	Гэрээ байгуулснаас хойш	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт	
Цусны дэлгэрэнгүй шинжилгээний хагас автомат анализатор	<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтэлсэн Техникийн тодорхойлолтод зааснаар	1	Ширхэг	Төв аймаг, Зуунмод сум 1-р баг, Эрүүл мэндийн газар, өөрийн байранд	Гэрээ байгуулснаас хойш	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт	
Биохимийн шинжилгээний хагас автомат анализатор	<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтэлсэн Техникийн тодорхойлолтод зааснаар	1	Ширхэг	Төв аймаг, Зуунмод сум 1-р баг, Эрүүл мэндийн газар, өөрийн байранд	Гэрээ байгуулснаас хойш	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт	

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [too] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал Үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 3.2. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[100]<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>  | 3.3. Алданги оногдуулах хувь: <b>[0,05]</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>[10]</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]